

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 4-р сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

“МЕРЕКС” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал “БАЯНГОЛ” зочид буудлын хурлын танхимд 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт эхлэж, нийт 2 цаг үргэлжлэн, 12:00 цагт өндөрлөв.

Б.Эрдэнэжаргал: Мерекс ХК-ийн саналын эрх бүхий нийт 65,005,000 ширхэг хувьцаанаас өнөөдрийн хуралд нийт 54,844,061 ширхэг хувьцаа буюу 84,37 хувьтайгаар хувьцаа эзэмшигчид хуралд өөрийн биеэр болон эчнээ санал хураалтаар оролцож байгаа учраас энэ хурлыг хүчин төгөлдөр гэж тооцож болно.

Н.Улаанхүү: Хурлын ирц бүрдсэн тул хурлаа эхлэе. Эрхэм хүндэт Мерекс ХК-ийн хувьцаа эзэмшигчид Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэж, Хувьцаа эзэмшигчийн хурал нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хурал дараах дарааллын дагуу явагдана.

- ✓ Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах.
- ✓ Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах
- ✓ Асуулт хариулт
- ✓ Хурлаар хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хураалт
- ✓ Тооллогын комисс тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлаас гарсан шийдвэр тогтоолыг танилцуулах

Эхлээд Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2015 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулъя.

Мерекс ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2016 оны төлөвлөгөөний талаарх илтгэлийг компанийн дүрмийн хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мерекс ХК-ийн ТУЗ нь компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, компанийн Дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг мөрдөж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, компанийн үйл ажиллагааг жигдрүүлэн, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, ашиг орлогыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаа.

2015 онд компанийн нийт хамт олон Мерекс ХК-ийн ТУЗ-өөс баталсан 2015 оны төлөвлөгөөний дагуу түүхий эд бэлтгэлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, шинэ санал санаалчлагыг дэмжих, санхүүгийн хямд эх

Хурлын тэмдэглэл

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

үүсвэрийг олж ашиглахад чиглэгдсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нөөц бололцоогоо дайчлан ажилласан. Үүний үр дүнд 2015 онд дэлхийн болон Монголын эдийн засагт тулгарсан хямралаас шалтгаалан барилгын салбарын хувьд хүндхэн жил байсан хэдий ч Мерекс ХК нь үйлдвэрлэлээ амжилттай явуулж, зах зээлд өөрийн орон зайг бий болгож, харилцагч байгууллагуудынхаа өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж, ашигтай ажилласан жил байлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 3-р сарын 18-ны өдрийн хурлаар компанийн 2015 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэн, бизнес төлөвлөгөөний ерөнхий биелэлтийг үзүүлэлт бүрээр хангалттай гэж үзэн, энэхүү дүгнэлтийг ийнхүү Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар тогтсон болно.

Мерекс ХК нь дээрх дүгнэлтэнд дурьдсанаар өнгөрсөн онд энэ салбарын хувьд хүндрэлтэй хямралтай жил хэдий байсан ч ашигтай ажиллаж чадсан. Үйлвэрлэлээ хэвийн явуулж мөн энэ жилийн үйл ажиллагаагаа эхлүүлэх шаардлагатай түүхий эдийн бэлтгэлийг хангасан болно. Компанийг өнгөрсөн онд хангалттай ажилласан гэж дүгнэж байна.

Одоо компанийн 2015 оны үйл ажиллагааны тайланг тус компанийн Гүйцэтгэх захирал М.Мөнхзолбоо танилцуулна.

М.Мөнхзолбоо: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Манай компани нь 2012 онд УБ хотод үүсгэн байгуулагдаад 2014 оны 08-р сард үйлдвэрээ бүрэн барьж дуусгасан. 2014 оны 8-11 сарын хооронд туршилтын үйлдвэрлэл хийж, 2015 онд ерөнхийдөө үйлдвэрээ бүрэн шалгасан гэж хэлж болно. Үйлдвэрлэлийн хувьд төлөвлөгөө 40,000 м3 бетон зуурмаг үйлдвэрлэх байсан боловч төлөвлөгөөндөө хараахан хүрэлгүй 34,688.5 м3 үйлдвэрлэж, НӨАТ-гүй дүнгээрээ нийт 4,6 тэрбум борлуулалт хийсэн. Барилгын салбарын хямрал ерөнхийдөө Улаанбаатар хотын хүрээнд хүчтэй байсан. Улаанбаатар хотод нийт 80-аад бетон зуурмагийн үйлдвэр ажилладагаас 50-60 хувь нь өнгөрсөн жил ажиллаж чадаагүй. Ийм хүнд үед 34,000 гаруй м3 зуурмаг үйлдвэрлэсэн нь өөрсдийн хувьд компанийг хангалттай ажилласан гэж дүгнэж байна. Санхүүгийн ашигтай ажиллагааны хувьд 4,6 тэрбум борлуулалт хийж, татварын өмнөх дүнгээр 213,9 сая төгрөгийн ашигтай ажилласан. Татварын дараах байдлаар 192,6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Н.Улаанхүү: Өнгөрсөн онд компанийн хувьд гарсан том дэвшилттэй зүйл нь Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 компанийн жагсаалтанд багтсан, ингэснээрээ өнгөрсөн 3-р сард Монголын хөрөнгийн бирж болон Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Энэ бол топ компаниудтай байгуулагддаг гэрээ юм. Цаашдаа энэ нь компанийн хувьцааны хөрвөх чадвар болон үнэлгээнд эерэг нөлөө үзүүлнэ гэж бодож байна. Өнгөрсөн онд нийт 1,919,507 ширхэг хувьцаа арилжигдаж, арилжаанд оролцсон ширхэг, үнийн дүнгээр идэвхтэй арилжигдсан хувьцааны тоонд орсон.

Өнгөрсөн онд компанийн засаглал ил тод байдлыг сайжруулах чиглэлээр дараах ажлууд хийгдсэн байна.

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

- ✓ Өмнө хэлсэнчлэн Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл, Монголын Хөрөнгийн биржтэй Компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр тунхаг бичиг байгуулсан.
- ✓ Компанийн өөрийн вэб сайт болон Монголын Хөрөнгийн Бирж, КЗҮЗөвлөл-ийн компанийн засаглалын порталтай сайт болох www.governance.mn вэб сайтуудыг ашиглан хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлэл тогтмол хүргэсэн.
- ✓ СХЗ-ны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журмын дагуу Компанийн үйл ажиллагаа, борлуулалттай холбоотой томоохон гэрээ хэлцэлийн талаар мэдээллийг тухай бүр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон зохицуулах байгууллагад хүргүүлэн ажилласан.
- ✓ Компанийн танилцуулга хийж, 300 хувь хэвлүүлж, тараасан. Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон Брокер дилерийн компаниудын төлөөллийг "Мерекс" ХК-ийн үйл ажиллагаатай танилцуулах арга хэмжээ зохион байгуулсан.
- ✓ Жил болгон зохион байгуулагддаг үзэсгэлэн, яармагуудад оролцож, компанийн үйл ажиллагааг танилцуулж ажилласан.
- ✓ Компанийн үйл ажиллагаа жигдэрч, ашигтай ажиллаж эхлэх хүртэл компанийн нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг СЗХ-с тусгаарлах шийдвэр гаргасан байсан. Компани нь үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн тул өнгөрсөн оны 8-р сарын 28-ны өдөр СЗХ-ны Зөвлөл хуралдаж, тус хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөх шийдвэр гаргасан.

Мөн хүний нөөцийн сургалт, хөгжлийн чиглэлээр тодорхой ажлуудыг тогтмол зохион байгуулж ажилласан.

Өнгөрсөн онд компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 3-р сарын 30-нд хуралдуулсан. Хурлын ирц 84%-тай байж, хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. Компанийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
4. ТУЗ-ийн 2015 оны цалин урамшууллын төсөв батлах
5. Компанийн дүрмийг өөрчлөх
6. Ногдол ашиг тараах эсэх

“Мерекс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл тайлант хугацаанд 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр, компанийн үйлдвэрлэл, удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудлаар зайлшгүй шийдвэл зохих асуудлуудыг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргаж, хяналт тавьж ажилласан.

Өнгөрсөн онд ТУЗ-ийн хурлыг биет болон цахим хэлбэрээр хийсэн. Гишүүдийн биечлэн оролцсон хурлыг 3 удаа хийж, 15 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Зарим яаралтай асуудлыг шийдвэрлэхийн тулд хурлыг цахим хэлбэрээр 2 удаа хийж тодорхой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хурлын тэмдэглэл

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг чиглэлээр нь ангилан үзвэл:

- ✓ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд буюу компанийн бизнес төлөвлөгөө, их хэмжээний хэлцэл болон борлуулалтын төлбөрт шилжүүлэн авсан хөрөнгийг худалдан борлуулах зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 7 удаа
- ✓ Санхүү, аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудлуудаар 5 удаа
- ✓ Компанийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой 1 удаа
- ✓ ТУЗ-өөс өгсөн даалгавар, чиглэлийг хянах чиглэлээр 1 удаа тус тус хуралдсан байна.

Компани нь нийгмийн хариуцлага, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үйлдвэрийн байгаа орчин нь өөрөө тоосжилт ихтэй, бохир мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд химийн тодорхой бодис хэрэглэгддэг учир энэ чиглэлээр зайлшгүй анхаарах хэрэгтэй байдаг. Түүнчлэн 2015 оны “Үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан хуулийн хугацаанд БОНХАЖЯ-аар баталгаажуулан, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ННХГ-т хүргүүлсэн.

Өнгөрсөн оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг нэгтгэн та бүхэнд хүргэлээ.

Одоо 2016 оны төлөвлөгөөг танилцуулая.

Энэ онд барилгын салбар дахь хямралтай байдал нь арилахгүй, өнгөрсөн оны нөхцөл байдал сайжрах шинж тэмдэг ажиглагдахгүй байгаа учраас компанийн ТУЗ нь үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 40,000 м3 зуурмаг үйлдвэрлэхээр төлөвлөж баталсан. Ингэснээр 5,6 тэрбум төгрөгийн борлуулалт хийх боломжтой гэж үзэж байна.

Төлөвлөгөөт борлуулалт хийснээр 375 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж ногдол ашгийн бодлогын хүрээнд цэвэр ашгийн 25%-иас багагүй хэмжээний ногдол ашиг хуваарилахаар тооцоолж байна. Үүнийг компанийн гүйцэтгэх удирдлага болон компанийн ажилтан нар биелүүлэн ажиллана гэдэгт найдаж байна.

Дараагийн танилцуулах асуудал бол хараат бус аудитын тайлан.

Бид компанийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргах компанийг сонгох зорилгоор аудитын 4 компаниас үнийн санал, ажлын туршлагын мэдээлэл авч ажилласан. Аудитын компанийг сонгохдоо үйлчилгээний үнэ, ажлын туршлага, тухайн компани нь Хувьцаат компанид аудит хийх зөвшөөрөлтэй эсэх гэсэн үндсэн 3 зүйлийг шалгуур үзүүлэлт болгосны дагуу хорооны гишүүдийн саналыг үндэслэн компанийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргах компаниар Нийслэл аудит ХХК-г сонгосон.

Ингээд хараат бус аудитын дүгнэлтийг та бүхэнд уншиж танилцуулья.

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

Танай байгууллагын 2015 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна. Аудитлагдсан санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав. Захирал Т.Сугарсүрэн гэсэн байна.

Санхүүгийн тайланг та бүхэн хурлын материалын танилцуулгаас харах боломжтой.

Энэ тайлангаар 2014 онд нийт активын дүн 5.6 тэрбум төгрөг байсан бол 2015 оны 12-р сарын 31-ний байдлаар 7 тэрбум төгрөг болж нэмэгдсэн байна.

Борлуулалтын орлогын хувьд 2014 онд үйдвэрийн үйл ажиллагаа бүрэн эхлээгүй байсантай холбоотойгоор 86.1 сая төгрөг байсан бол 2015 онд 4.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.

Борлуулалтын нийт өртөг нь 3.9 тэрбум төгрөг, үйл ажиллагааны нийт ашиг нь 682,4 сая төгрөг, үүнээс холбогдох зардлыг хассан татварын өмнөх дүнгээр 213.9 төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллаад үүнд татварын зардлыг хассанаар 192.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Одоо Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд дэвшиж байгаа хүмүүсээ танилцуулъя.

Эхлээд ердийн гишүүнд нэр дэвшигчдээ танилцуулъя. Үүнд:

- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Нанжид овогтой Улаанхүү. Иргэний харьяалал Монгол Улс, 1982 онд төрсөн. Эдийн засагч мэргэжилтэй. Одоо Стандарт Финаншл Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирлын ажил хийж гүйцэтгэж байна. 2005-2006 он, Дэлхийн банк, Тогтвортой амьжиргаа төсөл-д Судалгааны мэргэжилтэн, 2007-2009 он, Анод банк-д Эрсдлийн шинжээч, 2010-2014 он, Монет капитал ҮЦК, Хөрөнгө оруулалтын банкны хэлтсийн ахлахын ажил хийж байсан туршлагатай.
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч М.Мөнхзолбоо. Иргэний харьяалал Монгол Улс, 1979 онд төрсөн. Олон улсын харилцааны мэргэжилтэй. Одоо “Мерекс” ХК-ийн Гүйцэтгэх захирлын алба хашиж байгаа. 2005-2008 он, “Туризм, Хөндлөнгийн хяналт” ХХК-д Ахлах менежер, 2009-2011 он, “Актив хийц” ХХК-д Гадаад харилцааны ахлах менежерийн ажил хийж байсан туршлагатай.
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Д.Баттулга. Иргэний харьяалал Монгол Улс, 1982 онд төрсөн, Санхүү удирдлагын мэргэжилтэй. Одоо “Стандарт финанс” ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна. 2010-2012 он, “Апу трейдинг” ХХК-д Дотоод аудитор, 2010.02-2010.06 он “Нүүрсний зам” ХХК-д Ерөнхий Ня-Бо, 2005-2009 он, “Зоос банк” 110-р салбарын Зээлийн эдийн засагчаар ажилдаж байсан.
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч М.Ундрал. Иргэний харьяалал Монгол Улс, 1977 онд төрсөн, Менежер мэргэжилтэй. Одоо хувиараа бизнес эрхлэж байна. 2000-2001 он, “Нийтийн тээврийн зохицуулах газар”-т Санхүүгийн хэлтсийн ажилтан, 2003-2006 он, “Ти-Эс Эйч Трэйд” ХХК-д Менежер, “Түгээмэл Трейдинг” ХХК-д Менежер
- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Б.Хуяг. Иргэний харьяалал Монгол Улс, 1979 онд төрсөн, Англи хэл, Америк судлаач мэргэжилтэй. Одоо Стандарт Проперти групп ХК-ийн Дэд

Хурлын тэмдэглэл

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

захиралаар ажиллаж байна. 2008-2013 он, Хера Экуйпмент ХХК-д Худалдааны хэлтсийн ахлах ажилтан

- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшигч Ч.Жаргал. Иргэний харъяалал Монгол Улс, 1975 онд төрсөн. Санхүүч мэргэжилтэй. Одоо “Стандарт инвестмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна. 2002-2003 он, “Монголын нээлттэй нийгэмлэгийн хүрээлэн”-нд Иргэний нийгмийн хөтөлбөрийн Төслийн зохицуулагч, 2003-2009 он, “Их Британийн Хүүхдийг Ивээх сан”-ийн Төслийн ажилтан, Хөтөлбөрийн менежер-ээр ажиллаж байсан.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулья.

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч Н.Ичинхорлоо-Иргэний харъяалал Монгол Улс, 1953 онд төрсөн. Хуульч мэргэжилтэй. Одоо Өмгөөлөлийн “Монгол Зарга” Нөхөрлөл-ийн Захиралаар ажиллаж байна. 1992-1994 он, “Хууль зүйн яам”,-нд Мэргэжилтэн, 1994 он, Архангай аймгийн сум дундын шүүхийн Ерөнхий Шүүгч, 2001-2007 он, Баянгол дүүргийн шүүхийн Ерөнхий Шүүгч, 2007-2011 он, Хан-Уул дүүргийн шүүхийн Шүүгчээр ажиллаж байсан туршлагатай.

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч Г.Галбадрах. Иргэний харъяалал Монгол Улс, 1978 онд төрсөн Дулааны инженер мэргэжилтэй. Одоо “Од Хийморь” ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна. 2004-2008 он, “Барилга Хот Байгуулалтын Яам”-нд Мэргэжилтэн, 2009-2012 он, “Газрын харилцаа геодези зураг зүйн газар”,-т мэргэжилтнээр ажиллаж байсан.

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч Н.Өлзийхишиг. Иргэний харъяалал Монгол Улс, 1978 онд төрсөн. Программист мэргэжилтэй. Одоо Чингис хаан банк-нд ахлах программистаар ажиллаж байна. 2000-2001 он, “Эрдэнэт УБҮ”-д Инженер-программист, 2001-2007 он, “Анод банк”-нд Программист, ахлах программистын ажил хашиж байсан хүмүүс байна.

Компанийн үйл ажиллагаанд олон талаас нь дүгнэлт өгөх боломжтой гэж үзэж дээрх нэр дэвшигчдийг компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлсэн.

Ерөнхийдөө танилцуулах асуудлууд дуусаж байна. 2016 оны 03-р сарын 18-ны ТУЗ-ийн хурлаар компани хэдийгээр ашигтай ажилласан ч ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдсэн. Ногдол ашиг хуваарилахгүй шийдвэрийг дараах байдлаар тайлбарлаж байна. 1-рт, 2015 оны ашгийг эргэлтийн хөрөнгийн чадавхиа сайжруулах чиглэлээр зарцуулахаар шийдсэн. Ер нь эдийн засгийн хямралтай үед эргэлтийн хөрөнгийн чадавхи сайтай компаниуд тэсч үлдэж чаддаг.

2-рт, Компанийн тухай хуулийн 47.1.2-т зааснаар хуримтлагдсан алдагдлын дүнгээр нийт эздийн өмчийн дүн буурсан байгаа учраас 47.1.2-дах заалт хангагдаагүй тул энэ жил ногдол ашиг хуваарилах боломжгүй байна.

За одоо дээрх танилцуулагдсан асуудлууд болон ТУЗ-д нэр дэвшигчдээс асуух асуулт байвал асууна уу. Тэгээд асуулт хариултын дараа санал тооллогын хуудас тарааж өгнө.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Тайлангаас асуух асуулт байна.

-Авлага 1.7 тэрбум төгрөг байна. Энэ юуны авлага вэ?

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

-800 сая төгрөгийн өглөг байсан. Энэ юуны өглөг вэ?

-Одоо барилгын ажлууд эхэлж байна. Үүнтэй холбоотойгоор гэрээ хэлцлүүд хийгдсэн эсэх, өнөөдрийн хувьд нөхцөл байдал ямаршуу байна?

Н.Улаанхүү: Авлага, өглөгийн талаар Мөнхзолбоо захирал мэдээлэл өгнө.

М.Мөнхзолбоо: Барилгын зах зээл зөвхөн энэ жил ч биш сүүлийн 2,3-н жил хямралтай байгаа. Энэ байдал нь барилгын борлуулалт буурсантай мөн энэ зах зээлд бартерийн борлуулалт өндөр хувийг эзэлж байгаатай холбоотойгоор үүсээд байна. Манай энэхүү авлагын 1,3 тэрбум орчим төгрөгийн үнэд бартерийн гэрчилгээтэй болон гэрчилгээ нь гараагүй орон сууцууд байгаа. Үүнийг борлуулах зорилготой эзэмших хөрөнгө дээр бүртгүүлсэн боловч аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу бартерийн орон сууцын гэрчилгээ нь гараагүй байгаа учраас авлага дээр бичигдээд авлага маань өндөр харагдаад байгаа юм. Үлдсэн дүн нь түүхий эд бэлтгэлээ хангах зорилгоор урьдчилж төлсөн зардал байгаа юм. Өөрөөр хэлбэл үүнийг энэ жил түүхий эд хэлбэрээр хүлээж авна гэсэн үг.

Өглөг дээр өнгөрсөн жилийн гүйцэтгэж дуусаагүй байгаа одоо үргэлжилж байгаа ажлуудын барагдуулаагүй төлбөрүүд байгаа юм. Бартерийн байрны гэрчилгээ нь гараад буцаан түүхий эдийн худалдан авалтандаа бартер хийж, гаргах учраас дансны өглөг болон авлагын дүн цаашдаа буурна.

Ажил гүйцэтгэлийн хувьд энэ жил өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад цаг агаарын байдал хүйтэн байна. Тиймээс барилгын ажил өмнөх жилүүдээс орой эхэлж байгаа. Гэрээний хувьд гэвэл энэ жил одоогийн байдлаар 3-н гэрээ хийгээд байна. Борлуулалтын гэрээ, тээвэр түүхий эд материал нийлүүлэх, нэмэлт гэх зэргээр нийт 5-н гэрээ урьдчилсан байдлаар байгуулагдсан байна. Бетон зуурмаг нь цемент, элс, хайрга, нэмэлт, түлш зэрэг түүхий эдээс шууд хамаардаг бөгөөд үүнээс бэлэн мөнгөөр эргэлддэг түүхий эд нь цемент, түлш 2 юм. Цемент, түлшний татан авалтан дээрээ бид илүү их анхаарч ажиллах ба хөрөнгө их зарцуулах болно. Одоогийн байдлаар цементийн бэлтгэн нийлүүлэлтийн 3-н гэрээ байгуулсан байна. Бусад түүхий эд материал нь бэлэн байдаг учраас таталтыг бартераар хийх боломж өндөр байдаг, түүнчлэн өнгөрсөн жил байгуулагдаж, үргэлжилж байгаа гэрээнүүд бий.

Манай компани “Барилгын хөгжлийн төв”-өөс гаргасан зааврын дагуу уулын дайрга ашиглаж байгаа. Хайргыг ашиглаж болох боловч өндөр марк-аар зуурмаг гаргахад тохиромжгүй байдаг ба энэ нөхцөлд дайрга нь зөвшөөрөгдсөн байдаг. Материалын таталтыг бид Био талаас нь хийдэг. Цементийн хувьд Дорноговь аймагт Монцемент үйлдвэр шинээр байгуулагдсан, Хөтөл ХХК хүчин чадлаа нэмж нэг зуух нэмсэн, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дээр Хятадын төрийн өмчит 1 сая тонны хүчин чадалтай үйлдвэрүүд шинээр байгуулагдаад байна. Импортын цементийн татварыг мөн 20%-аар өсгөсөн байгаа. Эдгээрээс шалтгаалан энэ жил цементийн үнэ, нийлүүлэлт харьцангуй тогтвортой байна гэж бодож байна. Дээр дурдсан 3-н үйлдвэр 3-лаа 1 сая тонны хүчин чадалтай болохоор нийлүүлэлт эрс сайжирна гэж үзэж байна. Дээрх үйлдвэрүүд зэрэг ажиллаад нийлүүлэлт өсөөд ирэхэд зах зээлийн борлуулалтанд эерэгээр нөлөөлөх байх гэж найдаж байна.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: -Хараат бус гишүүд энэ хуралд бүгд ирсэн үү?

Хурлын тэмдэглэл

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

- Энэ хуримтлагдсан алдагдал юунаас үүссэн бэ?

- Нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг яагаад тусгаарласан юм бэ?

М.Мөнхзолбоо: 1 нэр дэвшигч Хараат бус гишүүнд, 2 нэр дэвшигч Ердийн гишүүнд шинээр нэр дэвшиж байгаа бөгөөд бусад нэр дэвшигчид ТУЗ-д улиран сонгогдохоор нэр дэвшиж байна.

2013 оны 12-р сард СЗХ нь Мерекс ХХК-ийн нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх хүсэлтийг хэлэлцэж, 514 дүгээр тогтоолоор баталж, 2014 оны 1-р сард Монголын хөрөнгийн бирж манай компанийн үнэт цаасыг бүртгэж авснаар Мерекс нь хувьцаат компани болсон. Бетон зуурмагийн зах зээл дээрх 2 дах хувьцаат компани болж гарч ирсэн. Анх компани нь 2 үүсгэн байгуулагчтай байсан, компанийн үйл ажиллагаа тогтворжиж, ашигтай ажиллаж эхлэх хүртэл компанийн нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тусгаарлах буюу худалдан борлуулах, шилжүүлэхийг СЗХ-оос түр хааж түтгэлзүүлсэн байгаа юм. 2014 онд үйл ажиллагаа маань эхлээд 2015 онд үйл ажиллагаа жигдрэн, тогтвортой болсон үед тухайн байдлаа тодорхойлж Санхүүгийн зохицуулах хороонд бид нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлүүлэх хүсэлт гаргаж, улмаар СЗХ нь уг асуудлыг Зөвлөлийн хурлаараа хэлэлцэж тусгаарлалтаас чөлөөлөх шийдвэр гаргасан.

Н.Улаанхүү: 2014 онд үйлдвэрийн үйл ажиллагаа эхлээгүй байсан учир 805.1 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдал үүсээд байсан бол 2015 онд ашигтай ажилласнаар тус дүн 748.2 сая төгрөг болж буурсан. Цаашид төлөвлөгөөний дагуу ашигтай ажиллаад явахад 1-2 жилийн дотор хуримтлагдсан алдагдалгүй болох боломжтой. 2014 онд үүссэн алдагдал бол компанийн тоног төхөөрөмж, машин техникийн элэгдлийн зардлаас үүссэн байгаа. Тайлангийн бүртгэлийн системээр хуримтлагдсан алдагдалд элэгдлийн зардал тусгагдах ёстой учраас алдагдал их харагдаж байна.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Бетон зуурмаг борлуулахдаа гэрээгээр нийлүүлэлт хийж байна уу? Бэлэн мөнгөөр хийж гүйцэтгэж байна уу?

М.Мөнхзолбоо: Ерөнхийдөө гэрээ байгуулж, ажиллаж байгаа. Зарим тохиолдолд бага хэмжээний нийлүүлэлтийг бэлэн мөнгөөр хийх тохиолдол бий.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Нийслэлээс 6м3-ээс дээш бетон зуурмаг тээвэрлэгч явуулахгүй гэсэн шийдвэр гаргасан байгаа үүнийг яаж зохицуулж байна.

М.Мөнхзолбоо: Үүнийг бодолцож манайх 6м3-ийн тээвэрлэгч машин авсан байгаа.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Зуурмагийн компаниуд үүнээс болж их алдагдал хүлээсээр байна энэ талаар.

М.Мөнхзолбоо: Бид эрсдэлээ тооцон анхнаасаа 6м3-ийн тээвэрлэгч машин авсан. Цөөхөн хэдэн үйлдвэр нь 7м3-ийн машинтай байдаг ба ихэнх зуурмагийн үйлдвэр нь 8-аас дээш м3-ийн машинтай. 6м3-аас дээш тээвэрлэгч явуулахыг хориглоод байхад дийлэнх үйлдвэрүүд 6м3-аас дээш тээвэрлэгч машинуудаа явуулсаар байгаа.

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Үйлдвэр хаана байрладаг вэ?

М.Мөнхзолбоо: Сонгиноххайрхан дүүрэг, Сонсголонгийн зам, Төв цэвэршүүлэх байгууламжийн урд талд байрладаг.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Машиныудаа бүгдийг ашиглаж байгаа юу?

М.Мөнхзолбоо: Үгүй. Өнгөрсөн жил 10-аад машин ашигласан. Энэ нь эргэлтийн хөрөнгө болон төлбөрийн нөхцлөөс шалтгаалан бэлэн мөнгөний урсгал саарсанаас тээврийн хэрэгсэлд шаардагдах урсгал засвар үйлчилгээ хийгдээгүйгээс шалтгаалсан. Бэлэн мөнгөний эргэлт бага байгаа учраас урсгал засвараа хийх ажил удаашраад байгаа юм. 12 машинаа бид хөдөлгөөнд оролцуулахын тулд зохих хэмжээний хөрөнгө шаардлагатай байгаа. Бидний зорилго 17-18 машиныг үйл ажиллагаандаа ашиглана гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/:Зарим үйлдвэрүүд ашиглахгүй машиныудаа жолооч нартаа түрээслэсэн байдаг. Ингэж болдоггүй юм уу.

М.Мөнхзолбоо: Та Ремикон ХК-г хэлж байна уу.

Хувьцаа эзэмшигч: Тийм.

М.Мөнхзолбоо: Бидний тооцоогоор машинаа бид өөрсдөө ашигласан нь илүү зөв байгаа юм.

Хувьцаа эзэмшигч: Түрээслэх тал дээр асууж байна.

М.Мөнхзолбоо: Түрээслэх тал дээр хувь машинтай хүмүүс их олон болсон, мөн ажил багассан үед түрээслэх хүн ховордсон тул, өөрсдөө жолооч чалинжуулаад явуулсан нь илүү ашигтай байгаа юм.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Энэ жилийн хувьд шинээр баригдах болон үргэлжлэх ямар томоохон төслүүд байна вэ?

М.Мөнхзолбоо: Байгаа, бидний хувьд хэлэлцээр хийж байгаа 3-н гэрээ байна. Энэ жилийн хувьд Гэр хорооллын дахин төлөвлөлтийн барилгын ажлууд, мөн Буянт-Ухаа хорооллын барилгын ажил үргэлжилнэ.

Асуулт /Хувьцаа эзэмшигч/: Хийцийн үйлдвэрлэл хийх үү?, хурлын материалд дурьдагдсан байна.

М.Мөнхзолбоо: - Манай үйлдвэрийн хувьд тог нь байна, 2 га газар байна энэ газрын 70 хувийг л ашиглаж байна. Өөрсдийн энэ нөөц бололцоогоо ашиглан бетон хийц үйлдвэрлэх талаар судалгаа хийж байна. 2016 онд энэ чиглэлээр зарим нэг ажлууд зохион байгуулах төлөвлөгөөтэй байгаа.

Н.Улаанхүү: -Та бүхэнд өөр асуулт, тодруулах зүйл байна уу.

- Тооллогын дүн гарсан байна. Стандарт инвестмент ҮЦК-ийн үнэт цаасны дилер Б.Эрдэнэжаргал тооллогын дүнг танилцуулна.

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

Б.Эрдэнэжаргал: Өнөөдрийн Мерекс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж буй асуудлуудад өөрийн биеэр болон эчнээ санал хураалтаар оролцсон хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг танилцуулъя.

- Санал хураалтаар компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг **100 хувийн** саналтайгаар баталсан байна.

- Дараагийн хэлэлцсэн асуудал-ТУЗ-ийн 2016 оны зардлын төсвийг **100 хувийн** саналтайгаар баталсан байна.

- ТУЗ-ийн Ердийн гишүүдэд нэр дэвшиж байгаа Н.Улаанхүү, М.Мөнхзолбоо, Д.Баттулга, М.Ундрал, Б.Хуяг, Ч.Жаргал нар тус бүр **16,67** хувийн санал авсан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа Г.Галбадрах, Н.Ичинхорлоо, Н.Өлзийхишиг нар тус бүр **33,33** хувийн санал авсан байна. Ингэснээр эдгээр нэр дэвшигчид нь Мерекс ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдож байна.

Н.Улаанхүү: Одоо 15 минутын цайны завсарлагын дараа хурлаас гарах тогтоолын төслүүдийг танилцуулж, хурлаа өндөрлүүлъя.

Н.Улаанхүү: За ингээд тооллогын дүнг үндэслээд тогтоолын төслүүдийг танилцуулъя.

Тогтоол-1

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Мерекс” ХК-ийн 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Тогтоол-2

Та бүхэн хурлын материал дээрээс ТУЗ-ийн 2016 оны зардлын төсвийг харсан байх. Нийтдээ 25,1 сая төгрөг төсөвлөгдсөн байгаа.

Компанийн тухай хуулийн 62.1.13 заалт болон Мерекс ХК-ийн 2016 оны 04-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг хавсралтаар БАТАЛСУГАЙ.

Нэг хуралдаанд оролцохтой холбоотой зардлыг гишүүдэд 300,000 төг, ТУЗ-ийн дарга 400,000 төг, бусад зохион байгуулалт болон томилолттой холбоотой зардлууд нийлээд 25,1 сая төгрөг болж байна.

МЕРЕКС ХУВЬЦААТ КОМПАНИ

ТУЗ-ийн гишүүдээ сонгох тухай тогтоол-3

Компанийн тухай хуулийн 62.1.7 дах заалт, “Мерекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:
Ердийн гишүүдэд:

- Н.Улаанхүү
- М.Мөнхзолбоо
- Д.Баттулга
- Б.Хуяг
- М.Ундрал
- Ч.Жаргал

Хараат бус гишүүдэд:

- Н.Ичинхорлоо
- Г.Галбадрах
- Н.Өлзийнхишиг нарыг СОНГОСУГАЙ.

Компанийн үр ашигтай ажиллагааг хууль журмын дагуу удирдан зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг БОЛГОСУГАЙ.

-За ийнхүү энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай зохион байгуулагдаж, холбогдох асуудлуудыг танилцуулж, хэлэлцэн, шийдвэрээ гаргалаа. Та бүхэнд хуралдаа идэвхтэй оролцсонд баярлалаа. Хурал хаагдсаныг үүгээр мэдэгдэж байна.

Хурлын тэмдэглэл бичсэн:.....С.ЖАВХЛАНТӨГС

ТУЗ-ийн НБД

Хянасан:.....



.....Н.УЛААНХҮҮ

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл